



ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2026 оны 08 сарын 13 өдөр

Дугаар 108

Улаанбаатар хот

Харилцаа холбооны сүлжээний дугаар олгох,
ашиглалтын хугацаа сунгах тухай

Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9 дэх заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Магадлан шалгах ажиллагааны 2026 оны 08 дугаар сарын 11-ний өдрийн дүгнэлтийн дагуу Харилцаа холбооны сүлжээний дугаарын ашиглалтын хугацаа сунгах хуулийн этгээд (2)-ийн жагсаалтыг хавсралт ёсоор баталсугай.

2. Мөн магадлан шалгах ажиллагааны 2026 оны 08 дугаар сарын 11-ний өдрийн дүгнэлтийн дагуу "Монголын мэргэшсэн авто инженерүүдийн холбоо" НҮТББ-д харилцаа холбооны сүлжээний 1-900-3003 дугаарыг 2 жилийн хугацаагаар олгосугай.

3. Харилцаа холбооны сүлжээний дугаар олгосон болон ашиглалтын хугацаа сунгасан хуулийн этгээдтэй гэрээ байгуулахыг Захиргааны удирдлага, хамтын ажиллагааны газар /З.Эрдэнэчулуун/-т, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус хорооны дарга /Ж.Бат-Эрдэнэ/-д тус тус даалгасугай.

ДАРГА

Ж.БАТ-ЭРДЭНЭ

ГИШҮҮД

Б.АНХБААТАР

Ц.ГАНЗОРИГ

Б.ДАГВАСҮМБЭРЭЛ

Ч.ЗОЛБАЯР

С.ТАМИР

А.ҮЙЛСТӨГӨЛДӨР

Харилцаа холбооны зохицуулах хорооны
2026 оны 08 дугаар сарын 13-ны өдрийн
108 тоот тогтоолын
хавсралт

Харилцаа холбооны сүлжээний дугаарын ашиглалтын хугацаа
сунгасан хуулийн этгээдийн жагсаалт

№	Хуулийн этгээдийн нэр	Дугаар	Ашиглах дугаар	Хугацаа	Дуусах хугацаа	Дугаарлалтын зориулалт
1	“Ондо” ХХК	30010662	1-800- 6666	2 жил	2028.08.22	Телефон ярианд суурилсан мэдээлэл, лавлах үйлчилгээ
2	Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ	30010665	1-800- 1313	2 жил	2028.09.12	Телефон ярианд суурилсан мэдээлэл, лавлах үйлчилгээ

----- оОо -----